

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/143/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт	14
4.3 Албан шаардлага.....	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 172

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/А4 20220309 172

025030374

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	267,660,361.68	283,905,322.08
35	БАРАА МАТЕРИАЛ	267,660,361.68	283,905,322.08
351	Түүхий эд материал	57,820,640.11	62,721,783.64
35110	Тусгай зориулалттай материал	57,820,640.11	62,665,783.64
35130	Эм боох материал	-	56,000.00
354	Хангамжийн материал	209,839,721.57	221,183,538.44
35410	Бичиг хэргийн материал	555,000.00	420,000.00
35420	Аж ахуйн материал	15,099,075.00	7,198,900.00
35460	Хүнсний материал	-	2,244,470.00
35470	Бусад хангамжийн материал	194,185,646.57	211,320,168.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,124,508,365.36	7,050,263,489.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,124,508,365.36	7,050,263,489.65
392	Биет хөрөнгө	5,334,608,365.36	5,260,363,489.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,634,773,617.03	5,673,497,035.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(440,944,926.22)	(561,797,783.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	513,750,187.00	567,390,287.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(443,021,698.78)	(463,964,455.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	231,778,409.41	232,338,409.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(170,256,506.33)	(195,629,285.89)
39217	Ном	8,529,283.25	8,529,283.25
393	Биет бус хөрөнгө	1,789,900,000.00	1,789,900,000.00
39301	Програм хангамж	1,254,860.00	1,254,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,254,860.00)	(1,254,860.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,789,900,000.00	1,789,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,392,168,727.04	7,334,168,811.73
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,392,168,727.04	7,334,168,811.73
51	Засгийн газрын хувь оролцоо	7,392,168,727.04	7,334,168,811.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,308,712,037.11	3,308,712,037.11
51101	Өмч: - төрийн	3,308,712,037.11	3,308,712,037.11
512	Хуримтлагдсан үр дүн	3,815,106,125.74	3,757,106,210.43
51210	Өмнөх үеийн үр дүн	3,815,106,125.74	3,815,106,125.74
51220	Тайлант үеийн үр дүн	-	(57,999,915.31)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	268,350,564.19	268,350,564.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,392,168,727.04	7,334,168,811.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,422,267,092.47	3,291,667,200.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,807,692.47	67,900,226.70
120	Нийтлэг татварын бус орлого	76,807,692.47	67,900,226.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,807,692.47	67,900,226.70
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,807,692.47	67,900,226.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,345,459,400.00	3,223,766,974.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,917,673,500.00	2,849,657,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,917,673,500.00	2,849,657,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,550,000.00	53,429,874.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,550,000.00	53,429,874.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	397,235,900.00	320,679,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	397,235,900.00	320,679,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,491,648,435.20	3,349,667,116.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,491,648,435.20	3,349,667,116.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,207,594,733.60	3,171,449,892.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,187,949,150.00	2,302,423,743.00
210101	Үндсэн цалин	1,261,835,699.00	1,191,533,582.00
210102	Нэмэгдэл	752,320,165.00	965,002,919.00
210104	Урамшуулал	173,793,286.00	145,887,242.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	273,183,448.12	296,352,066.61
210201	Тэтгэврийн даатгал	185,066,138.75	206,078,710.61
210202	Тэтгэмжийн даатгал	21,868,512.16	22,457,757.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,709,958.54	18,393,541.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,230,654.94	7,179,073.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,308,183.73	42,242,985.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	365,416,919.63	276,252,581.42
210301	Гэрэл, цахилгаан	17,865,350.63	17,257,995.42
210302	Түлш, халаалт	323,961,214.00	243,472,200.00
210303	Цэвэр, бохир ус	23,590,355.00	15,522,386.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,561,754.54	32,563,935.52
210401	Бичиг хэрэг	5,665,700.00	5,364,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,512,550.00	1,006,225.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,246,114.00	3,395,387.22
210404	Ном, хэвлэл	-	2,425,871.60
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,301,020.00	1,586,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,511,470.54	18,379,851.70
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	324,900.00	405,700.00
2105	Нормативт зардал	8,117,575.00	35,585,092.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	225,250.00	1,069,257.00
210502	Хоол, хүнс	7,892,325.00	33,905,410.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	610,425.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,405,019.00	13,849,480.00
210604	Урсгал засвар	17,405,019.00	13,849,480.00
2107	Томилолт, зочны зардал	7,506,200.00	2,031,500.00
210702	Дотоод албан томилолт	7,506,200.00	2,031,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,097,141.00	20,631,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,097,141.00	16,599,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	4,032,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	247,357,526.31	191,760,493.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,820,000.00	2,490,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	49,161,572.00	22,102,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	195,375,954.31	167,168,393.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	284,053,701.60	178,217,223.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,515,180.00	66,356,165.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,300,680.00	58,491,165.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,214,500.00	7,865,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	18,024.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,024.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,446,295.37	30,320,338.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,446,295.37	30,320,338.58
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	185,092,226.23	81,522,696.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	185,092,226.23	81,522,696.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(69,381,342.73)	(57,999,915.31)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,087,775.26	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,087,775.26	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(19,087,775.26)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(88,469,117.99)	(57,999,915.31)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,357,437,696.00	3,223,766,974.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,357,437,696.00	3,223,766,974.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,917,673,500.00	2,849,657,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,917,673,500.00	2,849,657,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,528,296.00	53,429,874.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,978,296.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,550,000.00	53,429,874.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	397,235,900.00	320,679,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	397,235,900.00	320,679,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,303,865,496.00	3,186,241,874.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,303,865,496.00	3,186,241,874.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,026,096,952.40	3,001,589,570.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,187,949,150.00	2,302,423,743.00
210101	Үндсэн цалин	1,261,835,699.00	1,191,533,582.00
210102	Нэмэгдэл	752,320,165.00	965,002,919.00
210104	Урамшуулал	173,793,286.00	145,887,242.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	272,982,536.77	296,352,066.61
210201	Тэтгэврийн даатгал	184,865,227.40	206,078,710.61
210202	Тэтгэмжийн даатгал	21,868,512.16	22,457,757.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,709,958.54	18,393,541.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,230,654.94	7,179,073.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,308,183.73	42,242,985.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	365,416,919.63	276,252,581.42
210301	Гэрэл, цахилгаан	17,865,350.63	17,257,995.42
210302	Түлш, халаалт	323,961,214.00	243,472,200.00
210303	Цэвэр, бохир ус	23,590,355.00	15,522,386.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,198,614.00	25,602,167.22
210401	Бичиг хэрэг	5,480,200.00	4,715,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	499,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,571,114.00	3,067,887.22
210404	Ном, хэвлэл	2,638,300.00	1,634,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,146,000.00	2,016,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,163,000.00	13,669,380.00
2105	Нормативт зардал	18,866,350.00	37,736,557.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,816,800.00	1,190,257.00
210502	Хоол, хүнс	5,776,550.00	29,714,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,273,000.00	6,831,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,148,519.00	19,416,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,739,000.00	5,309,900.00
210604	Урсгал засвар	17,409,519.00	14,106,680.00
2107	Томилолт, зочны зардал	7,506,200.00	2,031,500.00
210702	Дотоод албан томилолт	7,506,200.00	2,031,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,097,141.00	20,631,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,685,941.00	16,599,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,411,200.00	4,032,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,931,522.00	21,143,375.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,259,250.00	2,997,225.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,672,272.00	18,146,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	277,768,543.60	184,652,303.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,230,022.00	72,791,245.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,015,522.00	64,926,245.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,214,500.00	7,865,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	18,024.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,024.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,446,295.37	30,320,338.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,446,295.37	30,320,338.58
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	185,092,226.23	81,522,696.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	185,092,226.23	81,522,696.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	53,572,200.00	37,525,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	53,572,200.00	37,525,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	53,572,200.00	37,525,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	53,572,200.00	37,525,100.00
223001	Бусад хөрөнгө	53,572,200.00	37,525,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(53,572,200.00)	(37,525,100.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,308,712,037.11	273,035,435.43	3,898,890,372.49		7,480,637,845.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,684,871.24		4,684,871.24
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,308,712,037.11	273,035,435.43	3,903,575,243.73	-	7,485,322,716.27
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(4,684,871.24)	-	-	(4,684,871.24)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(88,469,117.99)		(88,469,117.99)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,308,712,037.11	268,350,564.19	3,815,106,125.74		- 7,392,168,727.04
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,308,712,037.11	268,350,564.19	3,815,106,125.74		- 7,392,168,727.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,308,712,037.11	268,350,564.19	3,815,106,125.74	-	7,392,168,727.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(57,999,915.31)		(57,999,915.31)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,308,712,037.11	268,350,564.19	3,757,106,210.43		- 7,334,168,811.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,170,337,100.00	3,058,494,065.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,170,337,100.00	3,058,494,065.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,058,243,700.00	2,991,067,820.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,302,863,900.00	2,302,423,743.00
210101	Үндсэн цалин	1,191,542,200.00	1,191,533,582.00
210102	Нэмэгдэл	965,424,400.00	965,002,919.00
210104	Урамшуулал	145897300.00	145887242.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	313,442,100.00	296,352,066.61
210201	Тэтгэврийн даатгал	222,167,600.00	206,078,710.61
210202	Тэтгэмжийн даатгал	22,818,600.00	22,457,757.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,254,900.00	18,393,541.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,563,700.00	7,179,073.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,637,300.00	42,242,985.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	306,572,200.00	276,252,581.42
210301	Гэрэл, цахилгаан	30,400,000.00	17,257,995.42
210302	Түлш, халаалт	243,472,200.00	243,472,200.00
210303	Цэвэр, бохир ус	32700000.00	15522386.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,139,000.00	20,130,567.22
210401	Бичиг хэрэг	2,031,400.00	2,031,400.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,071,200.00	3,067,887.22
210404	Ном, хэвлэл	1,638,400.00	1,634,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,246,100.00	1,246,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,751,900.00	11,751,280.00
2105	Нормативт зардал	57,021,700.00	37,736,557.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,190,300.00	1,190,257.00
210502	Хоол, хүнс	48,999,600.00	29,714,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,831,800.00	6,831,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,607,400.00	33,606,680.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	19,500,000.00
210604	Урсгал засвар	14,107,400.00	14,106,680.00
2107	Томилолт, зочны зардал	2,031,500.00	2,031,500.00
210702	Дотоод албан томилолт	2,031,500.00	2,031,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,532,000.00	6,532,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,032,000.00	4,032,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,033,900.00	16,002,125.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	2,997,225.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,033,900.00	13,004,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,093,400.00	67,426,245.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,093,400.00	67,426,245.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	109,593,400.00	64,926,245.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,170,337,100.00	3,058,494,065.25
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,849,657,500.00	2,768,134,803.83
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,849,657,500.00	2,768,134,803.83
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	320,679,600.00	290,359,261.42
132001	Орон нутгийн төсвөөс	320,679,600.00	290,359,261.42

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

#

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,429,874.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,504,774.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,121,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,471,600.00
210401	Бичиг хэрэг	2,684,500.00
210402	Тээвэр, шатахуун	99,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	770,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,918,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,409,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,409,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,099,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,099,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,141,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,141,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,383,024.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,365,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,365,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,024.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	18,024.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,925,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,925,100.00
223001	Бусад хөрөнгө	21,925,100.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,429,874.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,429,874.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,244,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,185,774.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 0Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сарын 24-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсролын газраас болон Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,510.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 52.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 34.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант онд нийт зардал буурсан учраас материаллаг байдлыг гүйцэтгэлийн үед 32.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58.0 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	267.7	283.9	(16.2)
Үндсэн хөрөнгө	7,124.5	7,050.3	74.2
Нийт хөрөнгө	7,392.2	7,334.2	58.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	7,392.2	7,334.2	58.0
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	3,308.7	3,308.7	-
Өмнөх үеийн үр дүн	3,815.1	3,815.1	-
Тайлант үеийн үр дүн	-	(58.0)	58.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	268.4	268.4	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,392.2	7,334.2	58.0

Бараа материалын дансны үлдэгдэл 16.2 сая төгрөгөөр өсөж, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 74.2 сая төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,334.2 сая төгрөг болж, 58.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 130.6 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилт, материаллаг өөрчлөлт нь санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 142.0 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан нь тогтмол зардал, хангамж, бараа материалын зардалтай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 4,382.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,177.4 сая төгрөгөөр бууруулан 3,204.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгээс 2,884.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 320.7 сая төгрөг нийт 3,204.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 2,849.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 320.7 сая төгрөг нийт 3,170.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,058.5 сая төгрөг зарцуулж, 81.5 сая төгрөгийг улсын төсөвт, 30.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 13.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 40.2 сая төгрөг нийт 53.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцлох асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад нийт 190.7 сая төгрөгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, орлого авсан хөрөнгийг кодлох талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 66 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн тооллого, тооцоо бодолт, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг үндсэн хөрөнгө тус бүрээр авч үзэх болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 230.4 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 1.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 228.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын орлого, зарлага 0.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг анхан шатны баримт үндэслэн залруулав.

4.2 Төлбөрийн акт

Аудитын түүвэр тооллогоор бараа материалын үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр дутагдсан.

Дотуур байрны хүүхдийн хоолны нормыг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин урсгал засварын зардлаас 1.3 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авсан.

Шилэн дансны нэгдсэн системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад зарлагын мөнгөн гүйлгээг 199.7 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн.

Батлагдсан төсвийг 10 хүртэл хувиар хэмнээгүй, тавилга эд хогшил худалдан авч 27.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
/сая төгрөгөөр/											
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р сургууль	4	3.6	1	0.4	2	1.9	1	1.3		
ДҮН		4	3.6	1	0.4	2	1.9	1	1.3		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р сургууль	2	226.8					2	226.8		
ДҮН		2	226.8					2	226.8		
НИЙТ ДҮН		6	230.4	1	0.4	2	1.9	3	228.1		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 12/А2370448
ХЭА-2022/143/НА-СТА ТШЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотуур байрны хүүхдийн хоолны нормыг 1,423.4 мянган төгрөгөөр хэтрүүлж, батлагдсан норм баримталж ажиллаагүй.

Энэ нь Засгийн газрын 2019 оны “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 450 дугаар тогтоолын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 төгрөгөөр тогтоосугай” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Батлагдсан нормыг хэтрүүлсэн 1,423.4 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын 1-р сургуулийн захирал Х.Алтанцэцэг, нягтлан бодогч Ц.Буянтогтох нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

023050053



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 13/А2370448
ХӨА 2022/143/НА-СТА-ТЦЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын түүврийн тооллогоор 522.0 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэл дутагдсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь::

1. Бараа материалаас дутагдуулсан 522.0 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын 1-р сургуулийн захирал Х.Алтанцэцэг, нягтлан бодогч Ц.Буянтогтох нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

231144297
СЮА0046 9074082

023050097



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 105/А2370448
ХЭА 2022/143/НА - ГТ ЖЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох зардлыг 27,115.3 мянган төгрөгөөр хэмнэж ажиллаагүй.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.4-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх,” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын 1-р сургуулийн захирал Х.Алтанцэцэг, нягтлан бодогч Ц.Буянтогтох нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 106/А2370МН8
ХЭА 2022/143/НА СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин урсгал засварын зардлаас 1,306.6 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авсан.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын 1-р сургуулийн захирал Х.Алтанцэцэг, нягтлан бодогч Ц.Буянтогтох нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

023000472



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 107/А2370448
ХЭА - 2022/143/НТ-СН-743

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад зарлагын мөнгөн гүйлгээг 199.7 сая төгрөгөөр мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болсон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд байршуулбал зохих мэдээллийг тогтсон хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын 1-р сургуулийн захирал Х.Алтанцэцэг, нягтлан бодогч Ц.Буянтогтох нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

8717141397
СЮА0046 9074082

020211 478